



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2019 оны 12 сарын 10 өдөр

Дугаар А/745

Арвайхээр

Газар эзэмших эрхийн гэрчилгээг  
бусдад шилжүүлэх тухай

Газрын тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.4, 38.6 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Газар эзэмшигч иргэний гаргасан хүсэлтийн дагуу Арвайхээр сумын 5 дугаар багийн Шинэ Арвайхээр-1 дүгээр гудамжны 17 тоотод байрлах Гүнхэвийн Болдын (ЙЮ61032594) үйлдвэрлэлийн зориулалттай 1000м<sup>2</sup> газрыг Үржин дэвших хоршоонд (2130106) зориулалтын дагуу 7 жилийн хугацаатайгаар газар эзэмших эрхийг шилжүүлсүгэй.

2. Дээрх газар эзэмших эрх нь баталгаажсан аж ахуйн нэгжтэй холбогдох хууль тогтоомжийн дагуу газар эзэмших гэрээ байгуулж, гэрчилгээ олгон, газрын улсын бүртгэлд бүртгэн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын дэргэдэх Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Ч.Гүнсэнхорол)-т даалгасугай.

3. Энэ захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2011 оны Дуудлага худалдаагаар газар эзэмшүүлэх эрх олгох тухай 301 дүгээр захирамжийн Г.Болдтой холбогдох заалтыг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



Г.ГАНБОЛД

011101409